

СҮМЫН ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ.

Б.БАЯРСҮХ

БАТЛАВ.

“КЛАССИКХАУС” ХХК-НЫ

ЗАХИРАЛ

Л.БАТТӨР

“НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХҮРЭЭЛЭНГИЙН БАЙГУУЛАМЖ, ТОХИЖИЛТ”  
АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Дугаар: ДУГАДЦСЗДТГ/202301008

Дэлгэрцогт сүм

Нэг талаас Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын ЗДТГ (цаашид “захиалагч” гэх) нөгөө талаас “КЛАССИКХАУС”ХХК (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох “Хавсралт”-д тодорхойлсон “зургийн даалгавар”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт” ажлын зураг, төсөв боловсруулах” ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг (цаашид “ажил” гэх) 5 500 000 / Таван сая таван зуун мянга/ (цаашид “гэрээний үнэ” гэх) төгрөгөөр гүйцэтгэх зөвлөхийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.
4. Гэрээний үнэ санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Санхүүжилтийг зураг, төсвийг бүрэн хүлээлгэн өгч, угсралтын ажил гүйцэтгэг шалгарсны дараа ажлын 7 хоног дотор санхүүжилт хийнэ.
5. Гэрээний нийт дүн: 5 500 000 төгрөг. Үүнээс:  
ОНХС: 5 500 000 төгрөг
6. Гүйцэтгэг нь “Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт хийх” ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хулээлгэн өгнө.
7. Гэрээ нь энд дурдсан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэллцийг орлоно.
8. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
9. Захиалагч нь гэрээний дагуу зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг цаг хугацаанд нь гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
10. “Нийтийн биеийн тамирын хүрээлэнгийн байгууламж, тохижилт” ажлын зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг батлагдсан гэрээт хугацаандаа гүйцэтгээгүй

- бол үүргийн үнийн дүнгийн 0,3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хулээнээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдхүй.
11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичиг, цахим хаягаар болон утсан холбоогоор харилцана.
12. Захиалагч нь гүйцэтгэгчийн төлөөлөлтэй ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах. Ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөлд албан үүргээс гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.
13. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

Маргааныг шийдвэрлэх

14. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн маргааныг харилцан тохиролцо замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
15. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЗДТГ-ЫН ДАРГА

С. НАРАНТУНГАЛАГ

Утас: 94889922



**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:

Г.БАТЦЭЦЭГ

Утас: 80089890

Хаяг: Улаанбаатар хот,  
Баянгол дүүрэг, 3-р хороо  
Монгол 99 төв 801 тоот  
Данс: 1410009493 /Голомт банк/  
И-мэйл: Battur.architect@gmail.com